



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

НИЙСЛЭЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТЫН АЛБАНД

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"2. Нийслэлийн оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/321, А/394 дүгээр захирамжийн дагуу нийслэлийн нутаг дэвсгэрийн төвийн 6 дүүрэгт хашаа, гарааш арга хэмжээний хэрэгжилт, одоогийн нөхцөл байдал, хүндрэлийн талаар цаашид авах арга хэмжээний санал, холбогдох мэдээллийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/321 дүгээр захирамжийн 2.2-т үүрэг болгосны дагуу гарааш арга хэмжээг хэрэгжүүлэн газар чөлөөлөх ажилд тухай бүр дэмжлэг үзүүлж, хэв журам сахиулж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т;
2. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/394 дүгээр захирамжийн 2.2-т үүрэг болгосны дагуу уг захирамжийн 2 дугаар хавсралтад тусгагдсан 46 байршилд хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага - Хотын стандарт мөрдүүлэх ажлыг эрчимжүүлж, яаралтай зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Хотын стандарт, хяналтын газар /С.Төмөрдулам/-т;
3. Газар чөлөөлөлт хийгдсэн байршлуудыг нийтийн эдэлбэр газарт бүртгэх ажлыг зохион байгуулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж хэлэлцүүлэхийг Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба /Г.Батзориг/-нд;
4. Газар чөлөөлөлт хийгдсэн байршлуудад тохижилтын ажлыг эрчимжүүлж ажиллахыг Захирагчийн ажлын алба /М.Баяраа/, дүүргүүдийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



1110200120